



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/10/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор:	Ц.Наранчимэг
	Утас: 261665	Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
	Аудитын менежер:	Э.Энхбаатар
	Утас: 260512	Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn
	Ахлах аудитор:	О.Баярмаа
	Утас: 261628	Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn
	Аудитыг гүйцэтгэсэн:	Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-ийн захирал:
	Утас: 99168735	О.Бурмаа
Аудитор:	Цахим хаяг: aetb.audit@gmail.com	
Утас: 99092231	Д.Даваасүрэн	
	Цахим хаяг: aetb.audit@gmail.com	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.3 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад орсон өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Албан шаардлага	21
5.2 Зөвлөмж	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТХТХ	Төрийн хэмнэлтийн тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуучлалын яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХБНГУ	Холбооны бүгд найрамдах герман улс



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026 04 02 № 06/329
танай _____-ны № _____-т

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ НЭГДСЭН
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
О.ЭРДЭНЭБАТ ТАНАА

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 2,571,066.9 мянган төгрөгийн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Өмнөх аудитаар өгсөн “Арилжааны банкинд байршуулсан 2,375,212.5 мянган төгрөгийн зээлийн хөрөнгийн бүртгэлийг санхүүгийн тайланд тусган залруулах” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй;
- Холбогдох эрх бүхий байгууллагын тушаал шийдвэргүй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 73 ширхэг үндсэн хөрөнгийг дахин үнэлгээ хийж, 160,216.2 мянган төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоож, санхүүгийн тайланд тусгасан;
- Авлагын дансанд бүртгэлтэй 30.2 мянган төгрөгийн авлага, 3,917.3 мянган төгрөгийн өр төлбөрийн тооцоог нийлж баталгаажуулаагүй;
- Эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүй 6 иргэнтэй шууд гэрээ байгуулж, ажлын даалгавар, гэрээ дүгнэсэн актгүй 21,222.3 мянган төгрөгийг олгосон;

- Ажил үйлчилгээний төлбөрийн 8,209.7 мянган төгрөгийг тухайн байгууллагын данс руу бус хувь хүний болон төслийн ажилтны дансанд тус тус шилжүүлсэн;
- Тайлант онд 9 иргэнд олгосон 22,586.8 мянган төгрөгийн ажил үйлчилгээний төлбөрөөс 2,258.7 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцож, тайлагнаагүй байна.

Эдгээр зөрчлүүд нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.1, 14.4.2, 14.4.3, 14.4.4, 14.4.5, 14.4.6, 14.4.7, 17 дугаар зүйлийн 17.1.11, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 28 дугаар зүйлийн 8.7, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1 гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Толилуулга ба тодруулга", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 1-ний 174 тоот тушаалаар Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам болон бүтэц, орон тоог шинэчлэн баталсны дагуу 2025 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын сонгон шалгаруулалтыг Сангийн яаманд хүргүүлэх байсныг хугацаанд нь хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс ба Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Германы Сэргээн босголт, зээлийн банк (KfW) Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хамтран хэрэгжүүлж буй 5 аймгийн тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн малчид, иргэдийн амьжиргааг дэмжих, бэлчээрийн доройтлыг бууруулах, нөхөн сэргээх, биологийн олон янз байдлыг хамгаалах зорилготой "Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн зээлийн дамжуулан зээлдүүлэх гэрээ"-ний хугацаа 2025 оны 7 сард дууссан боловч гэрээг сунгах ажлыг зохион байгуулаагүй байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,287,042,225.94	3,011,028,158.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,282,596,155.77	3,009,064,577.41
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,282,596,155.77	3,009,064,577.41
31210	Төгрөг	1,282,596,155.77	3,009,064,577.41
31223	Арилжааны банк дахь харилцах	1,282,596,155.77	3,009,064,577.41
33	АВЛАГА	2,642,700.17	1,343,554.27
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	723,413.79	30,278.98
33500	Бусад авлага	1,919,286.38	1,313,275.29
35	БАРАА МАТЕРИАЛ	1,803,370.00	620,027.00
35400	Хангамжийн материал	1,803,370.00	620,027.00
35410	Бичиг хэргийн материал	1,129,800.00	421,100.00
35440	Түлш, шатах тослох материал	-	42,927.00
35470	Бусад хангамжийн материал	673,570.00	156,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	147,445,793.36	265,603,343.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	147,445,793.36	265,603,343.84
39200	Биет хөрөнгө	147,445,793.36	260,692,343.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	277,025,000.00	300,550,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(195,256,497.12)	(122,268,687.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	129,110,490.00	127,013,490.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(70,961,538.98)	(79,860,286.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,853,863.26	53,277,235.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(57,325,523.80)	(18,019,406.74)
39300	Биет бус хөрөнгө	-	4,911,000.00
39301	Програм хангамж	7,447,500.00	4,911,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,447,500.00)	-
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,434,488,019.30	3,276,631,502.52
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	42,751,321.66	3,917,252.28
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	42,751,321.66	3,917,252.28
41300	Өглөг	42,751,321.66	3,917,252.28
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	17,999.53	-
41360	Бусад өглөг	42,733,322.13	3,917,252.28
41361	Байгууллагад төлөх өглөг	24,244,000.00	-
41365	Татварын өглөг	18,489,322.13	3,917,252.28
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,391,736,697.64	3,272,714,250.24
51	Засгийн газрын хувь оролцоо	1,391,736,697.64	3,272,714,250.24
51200	Хуримтлагдсан үр дүн	1,391,736,697.64	3,112,498,050.24
51210	Өмнөх үеийн үр дүн	4,178,132,892.85	1,391,736,697.64
51220	Тайлант үеийн үр дүн	(2,786,396,195.21)	1,720,761,352.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	160,216,200.00
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,434,488,019.30	3,276,631,502.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

<i>/төгрөгөөр/</i>			
Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	14,480,991,449.67	8,680,358,515.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,382,353,361.67	7,770,630,415.36
120	Нийтлэг татварын бус орлого	525,050,617.28	173,258,115.11
120009	Бусад орлого	-	534,821.91
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ	525,050,617.28	172,723,293.20
122	Тусламжийн орлого	12,857,302,744.39	7,597,372,300.25
1221	Хандив тусламж /дотоод	12,857,302,744.39	7,597,372,300.25
122002	Хандив тусламж - Гадаад	12,857,302,744.39	7,597,372,300.25
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,098,638,088.00	909,728,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,097,500,000.00	909,728,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,097,500,000.00	909,728,100.00
1340	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,138,088.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,138,088.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	17,032,887,020.39	7,243,856,900.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,845,887,971.75	3,761,774,423.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,133,156,470.99	3,523,010,188.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	594,005,411.24	465,463,883.01
210101	Үндсэн цалин	594,005,411.24	465,463,883.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,187,722.95	57,848,361.24
210202	Тэтгэмжийн даатгал	69,187,722.95	57,848,361.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,771,400.00	128,494,400.00
210304	Байрны түрээс	118,771,400.00	128,494,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,767,019.82	23,563,867.00
210401	Бичиг хэрэг	7,659,680.00	7,458,700.00
210402	Тээвэр, шатахуун	13,718,801.62	8,147,906.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	7,353,848.20	6,379,976.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,034,690.00	1,577,285.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,061,800.00	13,887,063.72
210604	Урсгал засвар	10,061,800.00	13,887,063.72
2107	Томилолт, зочны зардал	57,439,950.00	56,965,943.35
210702	Дотоод албан томилолт	56,889,950.00	56,965,943.35
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	550,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,188,741,716.08	2,731,477,735.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,183,782,668.08	2,731,477,735.57
210803	Даатгалын үйлчилгээ	4,785,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,048.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,181,450.90	45,308,934.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,640.00	2,730,285.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,180,810.90	42,578,649.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	712,731,500.76	238,764,235.31
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	525,050,617.28	172,723,293.20
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	525,050,617.28	172,723,293.20
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	187,680,883.48	66,040,942.11
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	187,680,883.48	66,040,942.11

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,186,999,048.64	3,482,082,476.70
2200	Дотоод эх үүсвэрээр	11,186,999,048.64	3,482,082,476.70
221001	Тоног төхөөрөмж	11,186,999,048.64	3,482,082,476.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(2,551,895,570.72)	1,436,501,614.94
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	305,985,426.96
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	305,985,426.96
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	234,500,624.49	21,725,689.30
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	234,500,624.49	21,725,689.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI)=(IV-V)	(234,500,624.49)	284,259,737.66
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VII)=(III)+(VI)	(2,786,396,195.21)	1,720,761,352.60

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,860,646,866.31	4,103,423,715.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	407,700.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	407,700.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	407,700.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	407,700.00	-
122	Тусламжийн орлого	2,762,579,166.31	3,193,695,615.89
122002	Хандив тусламж /гадаад/	2,762,579,166.31	3,193,695,615.89
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	1,097,500,000.00	909,728,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	1,097,500,000.00	909,728,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	160,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	160,000.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	160,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,406,992,836.00	1,420,725,264.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,406,992,836.00	1,420,725,264.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,219,311,952.52	1,354,684,322.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	568,610,843.24	480,007,329.13
210101	Үндсэн цалин	568,610,843.24	480,007,329.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,500,443.08	57,848,359.29
210201	Тэтгэврийн даатгал	44,672,486.14	39,336,885.64
210202	Тэтгэмжийн даатгал	6,033,099.45	4,627,868.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,057,747.89	2,313,934.47
210204	Ажилгүйдлийн даатгал	2,891,468.60	2,313,932.47
210205	Эрүүл мэндийн даатгал	11,845,641.00	9,255,737.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,771,400.00	128,494,400.00
210304	Байрны түрээс	118,771,400.00	128,494,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,851,748.20	20,969,976.00
210401	Бичиг хэрэг	6,998,000.00	6,750,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,500,000.00	7,050,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	7,353,848.20	6,379,976.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,999,900.00	790,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,389,800.00	13,887,063.72
210604	Урсгал засвар	10,389,800.00	13,887,063.72
2107	Томилолт, зочны зардал	58,147,650.00	56,965,943.35
210702	Дотоод албан томилолт	57,297,650.00	56,965,943.35
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	850,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	358,040,068.00	593,511,251.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	353,081,020.00	593,511,251.38
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,785,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	174,048.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	3,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	187,680,883.48	66,040,942.11
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	187,680,883.48	66,040,942.11

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	187,680,883.48	66,040,942.11
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,453,654,030.31	2,682,698,450.91
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	4,941,591,058.64	1,240,489,766.93
2200	Дотоод эх үүсвэрээр	4,941,591,058.64	1,240,489,766.93
222001	Тоног төхөөрөмж	4,919,991,058.64	1,239,969,766.93
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,600,000.00	520,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,941,591,058.64)	(1,240,489,766.93)
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	(234,500,624.49)	284,259,737.66
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	(234,500,624.49)	284,259,737.66
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(234,500,624.49)	284,259,737.66
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(2,722,437,652.82)	1,726,468,421.64
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,005,033,808.59	1,282,596,155.77
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,282,596,155.77	3,009,064,577.41

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

<i>/төгрөгөөр/</i>					
Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	4,178,132,892.85	4,178,132,892.85
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	4,178,132,892.85	4,178,132,892.85
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,786,396,195.21)	(2,786,396,195.21)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,391,736,697.64	1,391,736,697.64
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,391,736,697.64	1,391,736,697.64
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	160,216,200.00	-	160,216,200.00
19	Тайлант үеийн үр дүн	-	-	1,720,761,352.60	1,720,761,352.60
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	160,216,200.00	3,112,498,050.24	3,272,714,250.24

2.3 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	23,422,040,600.00	3,971,341,831.67	21,426,734,384.22	17.0
Татварын бус орлого	23,422,040,600.00	3,971,341,831.67	21,426,734,384.22	17.0
Тусламжийн орлого	23,422,040,600.00	3,971,341,831.67	21,426,734,384.22	17.0
Төсвөөс санхүүжих	944,380,600.00	777,646,215.78	166,734,384.22	82.3
Хандив тусламж /гадаад/	22,477,660,000.00	3,193,695,615.89	21,260,000,000.00	14.2
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,004,380,600.00	2,495,174,089.80	1,648,142,220.48	83.1
УРСГАЛ ЗАРДАЛ	3,004,380,600.00	1,355,204,322.87	1,648,142,220.48	45.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,004,380,600.00	1,355,204,322.87	1,648,142,220.48	45.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	550,000,000.00	480,007,329.13	69,992,670.87	87.3
Үндсэн цалин	550,000,000.00	480,007,329.13	69,992,670.87	87.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,750,000.00	57,848,359.29	10,901,640.71	84.1
Тэтгэврийн даатгал	46,750,000.00	39,336,885.64	7,413,114.36	84.1
Тэтгэмжийн даатгал	5,500,000.00	4,627,868.90	872,131.10	84.1
ҮОМШӨ-ний даатгал	2,750,000.00	2,313,934.47	436,065.53	84.1
Ажилгүйдлийн даатгал	2,750,000.00	2,313,932.47	436,067.53	84.1
Эрүүл мэндийн даатгал	11,000,000.00	9,255,737.81	1,744,262.19	84.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,150,000.00	128,494,400.00	1,655,600.00	98.7
Гэрэл, цахилгаан	450,000.00	-	450,000.00	-
Түлш, халаалт	1,200,000.00	-	1,200,000.00	-
Байрны түрээс	128,500,000.00	128,494,400.00	5,600.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	26,472,000.00	21,489,976.00	4,982,024.00	81.2
Бичиг хэрэг	6,750,000.00	6,750,000.00	-	100.0
Тээвэр, шатахуун	9,950,000.00	7,050,000.00	2,900,000.00	70.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,462,000.00	6,379,976.00	2,082,024.00	75.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,310,000.00	1,310,000.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	14,000,000.00	13,887,063.72	112,936.28	99.2
Урсгал засвар	14,000,000.00	13,887,063.72	112,936.28	99.2
Томилолт, зочны зардал	58,000,000.00	56,965,943.35	1,034,056.65	98.2
Дотоод албан томилолт	58,000,000.00	56,965,943.35	1,034,056.65	98.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,154,008,600.00	593,511,251.38	1,560,497,348.62	27.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,154,008,600.00	593,511,251.38	1,560,497,348.62	27.6
Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,139,969,766.93	(1,139,969,766.93)	
Тоног төхөөрөмж	-	1,139,969,766.93	(1,139,969,766.93)	

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	1,726,468,421.64	(1,726,468,421.64)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,282,596,155.77	(1,282,596,155.77)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,009,064,577.41	(3,009,064,577.41)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	10	10	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	9	9	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	10	10	-	100.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2	2	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн хэрэгжилт нь 2020 оны 03 дугаар сараас 2027 оны 02 дугаар сар хүртэл 7 жил зэрэгцэн явагдах ба Монгол Улсын баруун ба өмнөд хэсэгт сонгосон газар зүйн томоохон бүс нутгуудын буюу “Кластер” ач холбогдол бүхий эко-холбоос нутаг, тогтвортой хамгааллын менежментийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн газар (Засгийн газрыг төлөөлөн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам), Германы Засгийн газар (түүнийг төлөөлөн Германы Сэргээн Босголтын Зээлийн Банк)-ын хооронд байгуулсан гэрээний дагуу Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл 2020 оноос эхлэн хэрэгжиж байна.

Төсөл нь таван бүрэлдэхүүн хэсэгтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- Улсын хэмжээний тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний менежментийн төлөвлөлтийг сайжруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах;
- Томоохон нутаг дэвсгэрийг хамарсан холбоос нутаг буюу Кластер нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, тэдгээрийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;
- Кластерт хамрагдаагүй бөгөөд менежментийн онцлог хэрэгцээ шаардлага бүхий бие даасан долоон тусгай хамгаалалттай газрыг тогтоосон шалгуурын дагуу сонгож менежментийн болон бизнес төлөвлөгөөг нь сайжруулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх;
- Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд чадавхийг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- Чадавхжуулах, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн ажлыг зохион байгуулах.

Төслийн ерөнхий зорилго нь Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн (орчны бүс болон экологийн коридор) сүлжээг бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл нь үйл ажиллагаандаа Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 сарын 10-ны өдрийн 05 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавар.

Төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн зохицуулагчийн баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ашиглаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад орсон өөрчлөлт

Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөн нягтлан бодох бүртгэлийн журам”-д заасан санхүүгийн тайлан бэлтгэх үндэслэл, тайлбар тодруулгыг бүрэн бэлтгээгүй байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,842,143.5 мянган төгрөгөөр буюу 128.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,282,596.2	3,009,064.6	1,726,468.4
Авлага	2,642.7	1,343.6	(1,299.1)
Бараа материал	1,803.4	620.0	(1,183.3)
Үндсэн хөрөнгө	147,445.8	265,603.3	118,157.6
Нийт хөрөнгө	1,434,488.0	3,276,631.5	1,842,143.5
Өр төлбөр	42,751.3	3,917.3	(38,834.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,391,736.7	3,272,714.3	1,880,977.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,434,488.0	3,276,631.5	1,842,143.5

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,009,064.6 мянган төгрөг болж 1,726,468.4 мянган төгрөгөөр өссөн нь хандив тусламжийн 3,193,695.6 мянган төгрөгийн орлогыг хүлээн авсан нь голлон нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 1,343.6 мянган төгрөг болж 1,299.1 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагаас авах авлагыг бууруулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 620.0 мянган төгрөг болж, 1,183.3 мянган төгрөгөөр буурсан нь 43,249.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 44,432.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 265,603.3 мянган төгрөг болж 118,157.6 мянган төгрөгөөр өссөн нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 73 ширхэг үндсэн хөрөнгийг дахин үнэлгээ хийж, 160,216.2 мянган төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоосонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3,917.3 мянган төгрөг болж 38,834.1 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагад төлөх өглөг 24,244.0 мянган төгрөгийг, татварын өглөг 14,572.1 мянган төгрөгийг тус тус бууруулсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 3,272,714.3 мянган төгрөгөөр өссөн нь хандив тусламжийн 3,193,695.6 мянган төгрөгийн орлогыг хүлээн авсан нь голлон нөлөөлсөн байна.

Биет бус хөрөнгө: Тус төвийн биет бус хөрөнгийн дансанд 4,911.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн 3 программ хангамж, ВАССР веб сайт 1 бүртгэлтэй ба тайлант онд программ хангамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөр, лицензийн төлбөрт нийт 748.8 мянган төгрөгийг төлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төсөл хөтөлбөрийн нэгжийн 2025 оны батлагдсан төсөв ХБНГУ-ын Засгийн газраас 22,477,660.0 мянган төгрөгөөр, Монгол Улсын Засгийн газраас 944,380.6 мянган төгрөг, нийт 23,422,040.6 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр гадаадын хандив тусламжаас 3,193,695.6 мянган төгрөгийг, улсын төсвөөс 843,687.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулаагүй үлдэгдлийн 66,040.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80105	Гадаад тусламжаар гүйцэтгэх ажил	22,477,660.0	3,193,695.6	19,283,964.4	14.2
83112	Хөтөлбөр төслийн дотоод урсгал	944,380.6	843,687.2	100,693.4	89.3
	Нийт дүн	23,422,040.6	4,037,382.8	19,384,657.8	17.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийг БОАЖС, Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 236/887 дугаартай хамтарсан тушаалаар 14 хүний орон тоотой баталсан байна.

Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 1-ний 174 дүгээр тушаалаар “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж”-д шилжихэд мөрдөх түр журам болон бүтэц, орон тоог баталж, 2025 оны 11 дүгээр сарын 15-ны дотор ажилтнуудын сонгон шалгаруулалтыг Сангийн яаманд хүргүүлэх байсныг хугацаанд нь хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тайлант онд тус төслийн нэгж нь томилолтын зардалд нийт 55,822.7 мянган төгрөгийг, түрээсийн зардалд 128,494.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжүүлэх нэгж нь 2025 онд 4 хөтөлбөрийн хүрээнд нийт 36 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс хэрэгжилт 61.0 хувьтай байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

<i>/мянган төгрөгөөр/</i>						
д/д	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
	Тусгай хамгаалалттай газрын менежмент төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, тусгай	2020-2026		88.0	2,527,455.1	2,189,909.5

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах					
2	Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх	2020-2026	Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн болон нийлмэл/холбоос нутгуудын (орчны бүс болон экологийн коридор, кластер)	41%	18,836,333.7	9,763,114.8
3	Менежментийн онцлог хэрэгцээ бүхий бие даасан долоон тусгай хамгаалалтын газрыг тогтоосон шалгуурын дагуу сонгож менежментийн болон бизнес төлөвлөгөөг нь сайжруулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх	2020-2026	тогтвортой, үр дүнтэй менежментийг бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршино.	45%	6,836,523.8	5,221,582.1
4	Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	2020-2026		64%	742,759.7	544,820.6
		Дүн			28,943,072.3	17,719,427.0

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2025 оны худалдан авах төлөвлөгөөг 15 ажил үйлчилгээний нийт 25,217,922.6 мянган төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй, үүнээс тайлант онд санхүүжих дүнг 14,528,045.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Худалдан авалтын тендер шалгаруулалтаар 2,560,401.9 мянган төгрөгийн 4 ажил үйлчилгээний худалдан авалт амжилттай, 1,491,535.7 мянган төгрөгийн 3 тендер шалгаруулалт амжилтгүй, 1,597,203.1 мянган төгрөгийн 2 ажил үйлчилгээ үргэлжилж, 19,568,781.9 мянган төгрөгийн 6 ажил үйлчилгээний тендер шалгаруулалтын хугацаа хоцрогдолтой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төвийн үйл ажиллагааг сайжруулах, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийж, данс бүртгэлд тусгахгүй байх, ажлын даалгаваргүй гэрээг шууд байгуулдаг, гэрээг дүгнэж акт үйлддэггүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй ажил гүйлгээг данс бүртгэлд тусгахгүй байх, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, үүссэн авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах зэрэг зөвлөмжийг өглөө.

Аудитыг “Аав ээжийн тэнгэрлэг буян аудит” ХХК-ийн аудитор Д.Даваасүрэн, аудиторын туслах Б.Мөнгөнцэцэг нар гүйцэтгэж, ахлах аудитор О.Чулуунбаатар, захирал О.Бурмаа нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор О.Баярмаа, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж ажиллав.

Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт хүргүүлээгүй байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,845,888.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 58,458.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 3,226.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгөв.

Илрүүлэлт: Тайлант онд цай, чихэр, жимс, печень зэргийг 3,226.0 мянган төгрөгөөр худалдан авч төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэж тус тус заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж төсвийг үр ашиггүй хэмнэлтгүй зарцуулахгүй ажиллах зөвлөмж өгөв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 451,623.8 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, 1 албан шаардлага өгөв.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд 4 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 124,000.3 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээг, 324,397.5 мянган төгрөгийн зарлагын 5 гүйлгээг, нийт 448,397.8 мянган төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;" 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.1.4-т "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;" 6.1.1-т "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;" 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэж тус тус заасантай нийцэхгүй, Санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулах мэдээллийг хугацаанд нь байршуулдаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Иймд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,307,036.2 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага 1, албан шаардлага 1, зөвлөмж 4 хүргүүлснээс, хэрэгжилт 40.8 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Хариуцлага тооцох албан шаардлага	1	1,394,703.5	1	1,394,703.5	100.0
Албан шаардлага	1	291,375.0	1	291,375.0	100.0
Зөвлөмж	4	2,620,957.7	3	70,662.6	2.7
Дүн	6	4,307,036.2	5	1,756,741.1	40.8

Өмнөх аудитаар өгсөн арилжааны банканд байршуулсан 2,375,212.5 мянган төгрөгийн зээлийн хөрөнгийн бүртгэлийг санхүүгийн тайланд тусган залруулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөлд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн гэрээний хугацаа 2026 онд дуусах тул санхүүжилт, түүний хэрэгжилтийг бүрэн үнэлсэн эсэх асуудлыг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой илэрсэн нийт 136,691.2 мянган төгрөгийн 1 алдаа¹ арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулаагүй алдаа:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 73 ширхэг үндсэн хөрөнгийг дахин үнэлгээ хийж, 160,216.2 мянган төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоосныг Үндсэн хөрөнгийн тодруулгад 136,691.2 мянган төгрөгөөр дутуу тусгаж тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө “арилжааны/солилцооны бус ажил гүйлгээг бодит үнэ цэнээр хэмжинэ.” гэж заасантай нийцэхгүй^[06], санхүүгийн тайлагналын "Иж бүрэн байх", "Толилуулга ба тодруулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг дутуу тусгаж тайлагнасныг санхүүгийн тайланд залруулах зөвлөмж өгөв.

Аудитаар нийт 2,571,066.9 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрсэнд 8 албан шаардлага, 1 зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,571,066.9 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,512,608.0 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн арилжааны банкинд байршуулсан 2,375,212.5 мянган төгрөгийн зээлийн хөрөнгийн бүртгэлийг санхүүгийн тайланд тусган залруулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.3-д “бүх өр төлбөр”, 14.4.4-д “аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр”, 14.4.5-д “бүх орлого”, 14.4.6-д “бүх зардал”, 14.4.7-д “нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс” гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Арилжааны банкинд байршуулсан 2,375,212.5 мянган төгрөгийн зээлийн хөрөнгийн бүртгэлийг санхүүгийн тайланд тусган залруулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Холбогдох эрх бүхий байгууллагын тушаал шийдвэргүйгээр элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 73 ширхэг үндсэн хөрөнгийг дахин үнэлгээ хийж, 160,216.2 мянган төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоож, санхүүгийн тайланд тусгасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, мөн Төрийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант онд холбогдох эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүй 21,222.3 мянган төгрөгийн гэрээг 6 иргэнтэй байгуулж санхүүжилтийг олгосон, ажлын даалгавар, гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.", 35 дугаар зүйлийн 35.2-т "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлын даалгаваргүй гэрээг шууд байгуулдаг, гэрээг дүгнэж акт үйлддэггүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй ажил гүйлгээг данс бүртгэлд тусгадаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4. Ажил үйлчилгээний төлбөрийн 8,209.7 мянган төгрөгийг тухайн байгууллагын данс руу шилжүүлэхгүй хувь хүний болон төслийн ажилтны дансанд тус тус шилжүүлсэн байна. Үүнд:

- Дүүрэн дэлгэрэх бүрэн хүслэн ХХК-тай Ажил гүйцэтгэх 2025/04 тоот 3,828.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, төлбөрийг хувь хүний дансанд;
- Хаан болор ХХК-тай ажил гүйцэтгэх 2025/03 тоот 2,240.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, төлбөрийг төслийн санхүүгийн ажилтны хувийн дансанд;
- МИАТ ХХК-д шилжүүлэх томилолтын тийзний зардлын 1,756.7 мянган төгрөгийг төслийн санхүүгийн ажилтны хувийн дансанд;
- Васср домайны 385.0 мянган төгрөгийн төлбөрийг төслийн зохицуулагчийн хувийн дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" 8 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагад төлөх ажил, үйлчилгээний гэрээний төлбөрийг хувь хүний болон төслийн ажилтны дансанд шилжүүлдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5. Тайлант оны эцэст өр төлбөр дансанд бүртгэлтэй 3,917.3 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

6. Тайлант оны эцэст авлагын дансанд бүртгэлтэй 30,278.9 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

7. Тайлант онд 9 иргэнд олгосон 22,586.8 мянган төгрөгийн ажил үйлчилгээний төлбөрөөс 2,258.7 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутган тооцож тайлагнаагүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.19-д "суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг", 28 дугаар зүйлийн 28.7-д "Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1.6-д "үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Иргэнд олгох ажил үйлчилгээний төлбөрөөс ХХОАТ-ыг суутган тооцож, тайлагнадаггүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

8. Төслийн нэгжийн ашиглаж буй Интерактив Би Ай ХХК-ийн Эмералд санхүүгийн программ нь Сангийн яамнаас нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөлгүй, тодруулга журналууд нэр утга тодорхой татагдахгүй, аудитын хяналтын файл гарахгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-д "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программыг нийтэд мэдээлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн яамны нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөлгүй санхүүгийн программ ашиглаж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

5.2.1 Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

Илрүүлэлт: Тус төслийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалын маягтаар тайлагнаагүй, санхүүгийн тайлан бэлтгэх үндэслэл, тайлбар тодруулга бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн, зөв байх", Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.5.3-т "санхүүгийн тайлан бодон мөрийн зүйлс нэг бүрийг толилуулсан дэс дарааллын дагуу санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулсан зүйлсийн талаарх дэмжих мэдээлэл болон бусад тодруулга." гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг холбогдох хууль, журмын дагуу иж бүрэн, үнэн зөв бэлтгэж, хуульд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад хүргүүлж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
						Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 73 ширхэг үндсэн хөрөнгийг дахин үнэлгээ хийж, 160,216.2 мянган төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоосныг Үндсэн хөрөнгийн тодруулгад 136,691.2 мянган төгрөгөөр дутуу тусгаж тайлагнасан.	1	136,691.2	-	-	-	-	1	136,691.2	1	136,691.2
	Дүн	1	136,691.2	-	-	-	-	1	136,691.2	1	136,691.2

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх аудитаар өгсөн арилжааны банкинд байршуулсан 2,375,212.5 мянган төгрөгийн зээлийн хөрөнгийн бүртгэлийг санхүүгийн тайланд тусган залруулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	2,375,212.5	-	-	1	2,375,212.5	-	-
Тайлант онд холбогдох эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүй 6 иргэнтэй шууд гэрээ байгуулж, ажлын даалгавар, гэрээ дүгнэсэн актгүй 21,222.3 мянган төгрөгийг олгосон байна.	1	21,222.3	-	-	1	21,222.3	-	-
Ажил үйлчилгээний төлбөрийн 8,209.7 мянган төгрөгийг тухайн байгууллагын данс руу бус хувь хүний болон төслийн ажилтны дансанд тус тус шилжүүлсэн байна. Үүнд: 1. Дүүрэн дэлгэрэх бүрэн хүслэн ХХК-тай Ажил гүйцэтгэх 2025/04 тоот 3,828.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, төлбөрийг хувь хүний дансанд; 2. Хаан болор ХХК-тай ажил гүйцэтгэх 2025/03 тоот 2,240.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, төлбөрийг төслийн санхүүгийн ажилтны хувийн дансанд; 3. МИАТ ХХК-д шилжүүлэх томилолтын тийзний зардлын 1,756.7 мянган төгрөгийг төслийн санхүүгийн ажилтны хувийн дансанд; 4. Васср домайны 385.0 мянган төгрөгийн төлбөрийг төслийн зохицуулагчийн хувийн дансанд шилжүүлсэн байна.	1	8,209.7	-	-	1	8,209.7	-	-
Өглөгийн дансанд бүртгэлтэй 3,917.3 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	3,917.3	-	-	1	3,917.3	-	-
Авлагын дансанд бүртгэлтэй 30.3 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.	1	30.3	-	-	1	30.3	-	-
Тайлант онд 9 иргэнд олгосон 22,586.8 мянган төгрөгийн ажил үйлчилгээний төлбөрөөс 2,258.7 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцож тайлагнаагүй байна.	1	2,258.7	-	-	1	2,258.7	-	-
Холбогдох эрх бүхий байгууллагын тушаал шийдвэргүйгээр элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 73 ширхэг үндсэн хөрөнгийг дахин үнэлгээ хийж, 160,216.2 мянган төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоож, санхүүгийн тайланд тусгасан.	1	160,216.2	-	-	1	160,216.2	-	-
Дүн	7	2,571,066.9	-	-	7	2,571,066.9	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>									
Шилэн дансны цахим системд Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт, Санхүүгийн тайлан, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэрэг 4 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 124.0 сая төгрөгийн 2 гүйлгээг, зарлагын 324.4 сая төгрөгийн 5 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.	1	448,397.8				1	448,397.8		
Дүн	1	448,397.8				1	448,397.8		
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>									
Тайлант онд цай, кофег 3,226.0 мянган төгрөгөөр худалдан авч төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан байна.	1	3,226.0						1	3,226.0
Тус төслийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалын маягтаар тайлагнаагүй, санхүүгийн тайлан бэлтгэх үндэслэл, тайлбар тодруулга бэлтгээгүй байна.	1	-						1	-
Төслийн нэгжийн ашиглаж буй Интерактив Би Ай ХХК-ийн Эмералд санхүүгийн программ нь Сангийн яамнаас нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөлгүй, тодруулга журналууд нэр утга тодорхой татагдахгүй, аудитын хяналтын файл гарахгүй байна.	1	-				1	-		
Дүн	3	3,226.0				1	-	2	3,226.0
Нийт дүн	4	451,623.8				2	448,397.8	2	3,226.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1202/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/10/НА-СТА-ТХИ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн арилжааны банкинд байршуулсан 2,375,212,500.00 /хоёр тэрбум гурван зуун далан таван сая хоёр зуун арван хоёр мянга таван зуун/ төгрөгийн зээлийн хөрөнгийн бүртгэлийг санхүүгийн тайланд тусган залруулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь 7 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-д "бүх өр төлбөр", 14.4.4-д "аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр", 14.4.5-д "бүх орлого", 14.4.6-д "бүх зардал", 14.4.7-д "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс" гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Арилжааны банкинд байршуулсан зээлийн хөрөнгийн бүртгэлийг санхүүгийн тайланд тусган залруулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч О.Эрдэнэбат, санхүүгийн ажилтан Ж.Хэрлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

О.БУРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1203/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/10/МА-СТА-ТХИ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд холбогдох эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүй гэрээг 6 иргэнтэй байгуулж санхүүжилтийг олгосон, ажлын даалгавар, гэрээ дүгнэсэн актгүй 21,222,280.00 /хорин нэгэн сая хоёр зуун хорин хоёр мянга хоёр зуун наян төгрөг/-ийг олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.", 35 дугаар зүйлийн 35.2-т "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажлын даалгаваргүй гэрээг шууд байгуулдаг, гэрээг дүгнэж акт үйлддэггүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй ажил гүйлгээг данс бүртгэлд тусгадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч О.Эрдэнэбат, санхүүгийн ажилтан Ж.Хэрлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯАН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БУРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230



Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-47.Docx

1526181861



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1204/А0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/10/КА - СТА - ТХМ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажил, үйлчилгээний төлбөрийн 8,209,700.00 /найман сая хоёр зуун есөн мянга долоон зуун/ төгрөгийг тухайн байгууллагын данс руу шилжүүлэхгүй хувь хүний болон төслийн ажилтны дансанд тус тус шилжүүлсэн байна. Үүнд:

- Дүүрэн дэлгэрэх бүрэн хүслэн ХХК-тай Ажил гүйцэтгэх 2025/04 тоот 3,828,000.00 /гурван сая найман зуун хорин найман мянган төгрөг/-ийн гэрээг байгуулж, төлбөрийг хувь хүний дансанд;
- Хаан болор ХХК-тай ажил гүйцэтгэх 2025/03 тоот 2,240,000.00 /хоёр сая хоёр зуун дөчин мянган төгрөг/-ийн гэрээг байгуулж, төлбөрийг төслийн санхүүгийн ажилтны хувийн дансанд;
- МИАТ ХХК-д шилжүүлэх томилолтын тийзний зардлын 1,756,700.00 /нэг сая долоон зуун тавин зургаан мянга долоон зуун төгрөг/-ийг төслийн санхүүгийн ажилтны хувийн дансанд;
- Васср домайны 385,000.00 /гурван зуун наян таван мянган төгрөг/-ийн төлбөрийг төслийн зохицуулагчийн хувийн дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Байгууллагад төлөх ажил, үйлчилгээний гэрээний төлбөрийг хувь хүний болон төслийн ажилтны дансанд шилжүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч О.Эрдэнэбат, санхүүгийн ажилтан Ж.Хэрлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРДЭГ БУЯН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

О.БУРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1205/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/10/НА -СТА -ТХН

Зөрчил арилгах -тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст өглөгийн дансанд бүртгэлтэй 3,917,252.28 /гурван сая есөн зуун арван долоон мянга хоёр зуун тавин хоёр төгрөг хорин найман мөнгө/-ийн өглөгийн тооцоог нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1--д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өр төлбөрийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч О.Эрдэнэбат, санхүүгийн ажилтан Ж.Хэрлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БУРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1206/А0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/10/НА - СТА - ТХН

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст авлагын дансанд бүртгэлтэй 30,278.98 /гучин мянга хоёр зуун далан найман төгрөг ерэн найман мөнгө/-ийн авлагын тооцоог нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1--д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагын тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч О.Эрдэнэбат, санхүүгийн ажилтан Ж.Хэрлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БҮЯАН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

О.БУРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1207/А0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/10/НА - СТА - ТХЧ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 9 иргэнд олгосон 22,586,790.00 /Хорин хоёр сая таван зуун наян зургаан мянга долоон зуун ерэн төгрөг/-ийн ажил үйлчилгээний төлбөрөөс 2,258,679.00 /хоёр сая хоёр зуун тавин найман мянга зургаан зуун далан найман төгрөг/-ийн хувь хүний орлогын албан татварыг суутган тооцож тайлагнаагүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.19-д "суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг", 28 дугаар зүйлийн 28.7-д "Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1.6-д "үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Иргэнд олгох ажил үйлчилгээний төлбөрөөс хувь хүний орлогын албан татварыг суутган тооцож, тайлагнадаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч О.Эрдэнэбат, санхүүгийн ажилтан Ж.Хэрлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

О.БУРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлзүй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9009109
ATA16987
9025021411

Z: \Alban Shaardlaga 2026\0325 SAG-47.Docx

1526181869



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1209/АО150079

Улаанбаатар хот

САГ - 2026/10/НА - СТА - ТХ1

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Холбогдох эрх бүхий байгууллагын тушаал шийдвэргүйгээр элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 73 ширхэг үндсэн хөрөнгийг дахин үнэлгээ хийж, 160,216,200.00 /нэг зуун жаран сая хоёр зуун арван зургаан мянга хоёр зуун төгрөг/-өөр үнийг шинэчлэн тогтоож, санхүүгийн тайланд тусгасан.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", мөн Төрийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч О.Эрдэнэбат, санхүүгийн ажилтан Ж.Хэрлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, Ц.НАРАНЧИМЭГ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Э.ЭНХБААТАР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ О.БУРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1210/A0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/10/НА - СТА - ТХИ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд 4 төрлийн мэдээллийг /Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт, Санхүүгийн тайлан, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө/ хугацаанд нь байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5,000,000.00 /таван сая/ төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 удаагийн 124,000,316.00 /нэг зуун хорин дөрвөн сая гурван зуун арван зургаан төгрөг ерэн хоёр төгрөг/-ийн орлогын, 5 удаагийн 324,397,507.00 /гурван зуун хорин дөрвөн сая гурван зуун ерэн долоон мянга таван зуун долоон төгрөг/-ийн зарлагын, нийт 448,397,823.00 /дөрвөн зуун дөчин найман сая гурван зуун ерэн долоон мянга найман зуун хорин гурван төгрөг/-ийн гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор,"; 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.1.4-т "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор,"; 6.1.1-т "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор,"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн системд байршуулах мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч О.Эрдэнэбат, санхүүгийн ажилтан Ж.Хэрлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БУРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1208/АД150079

Улаанбаатар хот

САГ-2026/10/НА - СТА - ТХН

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төслийн нэгжийн ашиглаж буй Интерактив Би Ай ХХК-ийн Эмералд санхүүгийн программ нь Сангийн яамнаас нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөлгүй, тодруулга журналууд нэр утга тодорхой татагдахгүй, аудитын хяналтын файл гарахгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программыг нийтэд мэдээлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сангийн яамны нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөлгүй санхүүгийн программ ашиглаж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн зохицуулагч О.Эрдэнэбат, санхүүгийн ажилтан Ж.Хэрлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,
АУДИТЫН МЕНЕЖЕР,
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ,
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

О.БУРМАА

